


## “Баянхонгор аймгийн нийгэм эдийн засагт гангийн үзүүлэх нөлөө”

### судалгааны зарим үр дүнгээс:

Монгол орны хувьд жилийн дундаж агаарын температурын хамгийн их нь говьдоо 8.5°C байдаг бол хамгийн бага нь уулархаг нутагтай хасах 7.8°C байдаг. Харин жилийн дотор хамгийн бага температур нь нэгдүгээр сард хасах 31.1°C ээс -52.9°C байх ба хамгийн өндөр температур нь 7 дугаар сард 28.5°C-ээс 42.2°C байдаг. Хур тунадасны хувьд хэмжээ бага байх тусам байгалийн бүсээс хамаараад цаг хугацаа орон зайн хувьд янз бүр байдаг. Жилдээ Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулархаг нутагт 300-400 мм хээрийн бүсэд 50-250 мм цөлөрхөг хээрийн бүсэд 100-150 мм цөлийн бүсэд 50-100 мм, цөлийн бүсэд 50-100мм хур тунадас ордог (Л.Нацагдорж, 2009) байна.


Байгалийн хойд бүсээс урагшаа өндөр уул нурууд, тал хээр, цөлөрхөг хээр цөл болж шилжихийн хэрээр дулаан хангамж, салхины хурд нэмэгдэж харин тунадасны хэмжээ болон хөрсний чийг буурахын сацуу бэлчээрийн ургацын хэмжээ дагаад буурдаг.

Баянхонгор аймгийн хур тунадас, уур амьсгал, агаарын температурын өнөөгийн байдал, өөрчлөлтийн хандлагын талаар энэ хэсэгт авч үзье.




Зураг-1. Баянхонгор аймгийн 2012-2020 оны температурын өөрчлөлт

Баянхонгор аймгийн 2012-2020 оны агаарын температурын өөрчлөлт харагдаж байна. 2012 онд 13.7°C байсан бол 2014 онд 13°C болж буурсан байна. Түүнээс хойш 2017 он хүртэл эрчимтэй дулаарч 15.7°C хүрсэн байна. Үүнээс хойш 2020 онд 14.3°C болон буурсан ч цаашдаа температурын өөрчлөлт нэмэгдэх хандлагатай байна. Мөн 5 дугаар сар (10.3°C) болон 9 дүгээр сард (9.8°C) хамгийн бага дулаантай байсан бол 7 дугаар сард 18.4°C хамгийн их дулаардаг байна.



**Зураг-2. Баянхонгор аймгийн станц бүрийн нийлбэр хур тунадасны өөрчлөлт**  
 Баянхонгор аймгийн 7 станцын 2012-2020 оны хур тунадасны өөрчлөлт харагдаж байна. 2017 онд Эхийн гол 7,1 хамгийн бага хур тунадастай байсан бол 2016 онд Баянхонгор 330.9 хамгийн их хур тунадастай байна.




**Зураг-3. Баянхонгор аймгийн SPEI индексийн өөрчлөлт**  
 2012-2020 оны 5-9 сарын дундаж гангийн өөрчлөлтийг тооцож гаргасан байна. Улаан өнгөөр тухайн жил гантай байгааг ногоон өнгөөр зуншлага сайн жил болсныг харуулж байна. 2015 онд 0.04, 2016 онд 0.33 гангүй хэвийн байна. 2012, 2013, 2014, 2017, 2018, 2019, 2020, онуудад гантай байжээ. Хамгийн их ган болсон жил нь 2017 он -0.49 байна. 5сар 0.2, болон 9 сард 0.4 гангүй. 7 сард -0.8 хамгийн их гантай, 6 сар -0.4 болон 8 сард -0.3 гантай байна.

Баянхонгор аймгийн гангийн орон зайн тархалт.

Баянхонгор аймаг нь байгалийн бүс бүслүүрийн хувьд ойт хээрийн бүсээс эхлээд говь цөлийн бүсийг дамнан оршдог байгалийн эмзэг экосистемтэй аймаг юм. Бэлчээрийн экосистемийг уур амьсгалын хэлбэлзэл болон цаг уурын аюулт үзэгдэл, гангаас салгах боломжгүй юм.

С.А.Делиникайтес гангийн тухай ойлголт говь цөл нутагт байх ёсгүй, уур амьсгалын дундаж нөхцөлд зөвхөн битүү ургамалшилтай, усалгаагүй газар тариалан эрхэлж болох газарт л яригдах асуудал гэж үзсэн. (Л.Нацагдорж,2009) Ийм учир Баян-Өндөр,

Шинэжинст сумын ихэнх нутагт цөлийн бүсэд хамардаг учраас энэ сумдад ганг болоход түүнийг нь ган гэж тооцохгүй.



Зураг-4. Баянхонгор аймгийн гангийн орон зайн тархалт

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ган Баянхонгор аймгийн эхний жилүүдэд говь, хээрийн бүс нутаг буюу нутгийн баруун болон баруун хойд хэсгээр гангийн эрчимшилтэй байсан бол сүүлийн жилүүдэд нийт нутгийг хамарсан ган их тохиолдож байна. Энэ нь нийгэм эдийн засаг болон хөдөө орон нутагт малчидын аж ахуйн амьдралд Баянхонгор аймгийн нийгэм эдийн засагт маш их хохирол учруулж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

### **Ашигласан материал**

1. Алтанбагана,М. (2013). Уур амьсгалын өөрчлөлтөд нийгэм-экологийн тогтолцооны эмзэг байдлын үнэлгээ /Баянхонгор аймгийн жишээгээр/
2. Алтантуяа.Д (2022) “Хөдөөгийн нийгэм, эдийн засагт гангийн үзүүлж буй нөлөөллийн судалгаа”.
3. Нацагдорж.Л (2009) “Ган зуд”
4. Мягмаржав.И, Мягмарцэрэн.П, нар (2022). БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОТЬ 1: СУУРЬ СУДАЛГАА..
5. IPCC (2021) тайлан (Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын зөвлөл)